



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН 2018 ОНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА**

АЛТАЙ ХОТ
2018 ОН

ХУУДАС

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
СУГ	Стратеги удирдлагын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТЭЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХС	Сум хөгжлийн сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
АШУУИС	Анагаахын шинжлэн ухааны үндэсний их сургууль
ХАК	Хувийн аудитын компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах зорилготой.

Аудит хийхдээ Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, 4100-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж гүйцэтгэлээ.

ХОЁР: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ ХИЙХЭД БАРИМТАЛСАН БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, АУДИТ ХИЙХЭД УЧИРСАН БЭРХШЭЭЛ

Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн тайлангийн аудитын журмыг үндэслэн гарын авлага, СУГ болон САГ-аас СТАУС программ хангамжид хялбаршуулсан байдлаар мэдээлэл оруулах, аудитын явцад анхаарах асуудал, чиглэл, зөвлөмжийн дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дээрх бодлогын баримт бичгүүдийг тусгасан нэгж байгууллагын аудитын төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхдээ дараах горим, сорилуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар гарсан зөрчлийг санхүүгийн тайлангийн аудитаар давтан тооцоолж зөрчлийг арилгасан болно. Мөн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж аудитын тайланд тусгасан.
2. Мөнгөн гүйлгээний журналыг excel файлд хөрвүүлэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, гүйлгээ баланс, ажлын баримттай тулган аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.
3. Санхүүгийн тайлангийн толилуулгыг анхан шатны баримтаар гарсан гүйлгээтэй тохирч байгаа эсэхийг нотлохын тулд аудитын төлөвлөгөөнд тусгасан зардлын хувьд анхан шатны баримтаас зардлын зүйл ангийн дагуу төрийн сангийн хуулгыг дахин боловсруулж, НББ, санхүүгийн тайлан, тайлбар тодруулгуудын дүнтэй тулган баталгаажуулсан.
4. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актыг үзэж тулган баталгаажуулалт хийсэн.
5. Төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудтай харилцдаг аж ахуйн нэгж байгууллагуудаас өр, авлагын судалгааг авч аудитад ашиглан авлага, өглөгийг насжилт, зардлын зүйл анги, харилцагч бүрээр ангилж дүн шинжилгээ хийлээ.
6. Шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон цалингийн нөхөн олговрын судалгааг хийж санхүүгийн тайлангийн авлага, өглөгтэй тулгалт хийлээ. Төсөвт бодитойгоор хохирол учруулсан болон цаашид хохирол учруулах нь илэрхий болсон мөнгөн дүнг тооцож холбогдох байгууллагуудад зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.
7. Орон нутгийн өмчийн газраас аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаас бий болсон хөрөнгө, хөрөнгөтэй холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр, хөрөнгийн хөдөлгөөний судалгааг авч тулган баталгаажуулсан.
8. Зөрүүтэй болон алдаатай дансны бичилтийг тодруулж нягтлан бодогчтой харилцан ярилцсаны үндсэн дээр залруулга хийлгэж санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнууллаа.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд гарсан бэрхшээлтэй асуудлууд:

1. Интернетийн хурд удаан байсан тул СТАУС программын ажилбаруудыг хийж гүйцэтгэхэд цаг хугацаа их алдсан.

2. Санхүүгийн тайлангийн аудитаар хийж байгаа ажилбарууд их байгаа нь аудитын чанарт эерэг нөлөөтэй боловч хугацаанд сөргөөр нөлөөлж байна.
3. Санхүүгийн тайлан баталгаажуулах аудиттай зэрэгцэж гүйцэтгэл, нийцлийн аудитыг зэрэгцүүлэн хийхэд ачаалал их байлаа.

ГУРАВ: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН


Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх үүргийн хэмжээнд Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалтад хамрагдах 198 байгууллагын 293 санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийхээс 192 санхүүгийн тайланд Төрийн аудитын газрын ахлах аудитор, аудитор нар, 52 санхүүгийн тайланд ХАК-р гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр, ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангаар 37 санхүүгийн тайланд түүвэрт хамруулахаар, 12 санхүүгийн тайланд итгэл үзүүлэхээр МУ-ын Ерөнхий аудиторын 2017 оны А/134 тоот тушаалаар батлагдаж үүнийг дагуу санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын газрын хэмжээнд 244 санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийж дүгнэлт гаргахаас төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 санхүүгийн тайлан, шууд захирагчийн 168 санхүүгийн тайлан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 20 санхүүгийн тайлан, 22 төсөл сан хөтөлбөр, 7 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн нийт 218 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа.


Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв, Захирагчийн алба нь Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлан, холбогдох баримт материалаа ирүүлээгүй, “Зураг зүйн товчоо” ОНӨААТҮГ, “Орон сууц” ОНӨААТҮГ татан буугдсан гэх шалтгаанаар аудитад хамрагдаагүй, 19 сумдын Эмийн эргэлтийн сангийн Эмийн эргэлтийн сан статус тодорхой бус, улсын бүртгэлийн болон регистрийн дугааргүй хувь хүн үйл ажиллагаа явуулж байгаа, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих инкубатор төв үйл ажиллагаа явуулаагүйгээс дүгнэлт гаргаагүй болно. Мөн АШУҮИС-ийн Говь-Алтай дахь салбар сургууль АШУҮИС-ийн хамт ХАК-аар, “АЗЗА” ТӨҮГ ТУЗ-ын шийдвэрээр нэгдсэн байдлаар ХАК-аар аудит хийгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудитаас 52 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд одоогоор тухайн аудитын байгууллагын гэрээг дүгнэх шатандаа ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 147 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт /67.4%/, 65 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт /29.8%/, 5 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт /2.3%/, 1 санхүүгийн тайланд “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт /0.5%/ өглөө.




Нийт 34,429.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 4,991.3 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулан, 1,345.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 28,058.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 142 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 33.1 сая төгрөгийг зөрчилд зөвлөмж хүргүүлж, 4,124.7 сая төгрөгийн санхүүгийн, 200 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэсэн байна.



3.1.1 Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийг төсвийн захирагчаар нь авч үзвэл:

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 218 санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс Зөрчилгүй дүгнэлт авсан 147 байгууллагаас 126 нь ТШЗ, 11 нь ТТЗ, 1 нь ТЕЗ, 2 нь СХС, 3 нь бусад төсөл сан, 2 нь ТӨҮГ, 2 нь ОНӨҮГ-ууд эзэлж байна. Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагын 38 нь ТШЗ, 9 нь ТТЗ, 16 нь СХС, 1 нь бусад төсөл сан, 1 нь ОНӨҮГ эзэлж байна.




3.1.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг төсвийн захирагчаар нь авч үзвэл:

Тайлант онд илэрсэн нийт зөрчлийн 74.6% буюу 25,691.6 сая төгрөгийг төсвийн шууд захирагч эзэлж байна.


Төлбөрийн актын 50.0% буюу 672.6 сая төгрөгийг төсөл сан буюу Сум хөгжүүлэх сан, 21.7% буюу 291.9 сая төгрөгийг төсвийн шууд захирагч эзэлж байна.

Зөрчил арилгуулах албан шаардлагаас 85.3% буюу 23,938.0 сая төгрөгийг Төсвийн шууд захирагч, 6.4% буюу 1,805.1 сая төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн газрууд, хариуцлага тооцох албан шаардлагын 71.8 хувь буюу 102 нь төсвийн шууд захирагч, 16.9 хувь буюу 24 нь төсөл сан /СХС/ тус тус эзэлж байна.



3.1.3 Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийг салбар, нэгж байгууллагаар авч үзвэл:

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар Боловсролын салбарын 25 хувь нь зөрчилгүй дүгнэлтийг авсан байхад, Орон нутгийн төсөвт байгууллагуудын 11 хувь нь хязгаарлалттай дүгнэлт, ОНӨҮГ болон Боловсролын салбарын 1 хувь нь сөрөг дүгнэлтийг авчээ.




3.1.4 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг салбар, нэгж байгууллагаар нь авч үзвэл:

Тайлант онд илэрсэн нийт зөрчлийн 72% буюу 24,961.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 10.0 % буюу 3,372.0 сая төгрөгийг Боловсролын салбар, 7.0% буюу 2,307.0 сая төгрөгийг төсөл сан тус тус эзэлж байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн актын 55.0 % буюу 734.2 сая төгрөгийг төсөл, сан, 36.0 % буюу 483.9 сая төгрөгийг Орон нутгийн төсөвт байгууллага, 6.0% буюу 78.6 сая төгрөгийг Боловсролын салбар тус тус эзэлж байна.

Зөрчил арилгуулах албан шаардлагын 79.0 % буюу 22,070.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллагууд, 9.0% буюу 2,440.5 сая төгрөгийг Боловсролын салбар эзэлж байна.




3.1.5 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийг сүүлийн 3 оноор зэрэгцүүлэн судалгаа хийж үзвэл:

Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил албан шаардлага, төлбөрийн актыг харьцуулж үзвэл:

Илэрсэн зөрчил, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, хариуцлага тооцох албан шаардлагын хувьд өмнөх онуудтай харьцуулахад 2017 он нэлээд өндөр байна.


Өмнөх жилүүдэд санхүүгийн тайлангийн аудитын танилцуулгыг аймгийн ИТХ-д хүргүүлэн ажилдаа хариуцлагагүй хандсан, зөрчилтэй дүгнэлт авсан албан тушаалтанд арга хэмжээ авах тогтоолыг гаргуулан ажилладаг байсан боловч 2017 онд санхүүгийн тайлангийн аудитын танилцуулгыг хурлаар хэлэлцүүлээгүй мөн ҮАГ-аас ирж ажилласан ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилласнаар хариуцлага тооцох албан шаардлагын дүн өссөн үзүүлэлттэй байгаа болно.



Графикаас үзэхэд залруулгын дүн жил ирэх тусам буурсан байгаа нь нягтлан бодогчийн ур чадвар, стандартын мөрдөлт сайжирсныг тодорхойлж байна.

Харин зөрчил арилгах болон сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, төлбөрийн актын хэмжээ жилээс жилд өсөж байгаа нь төсөв захирагчдын хууль эрх зүйн мэдлэг хангалтгүй, төсвийн сахилга бат муу, ажлын хариуцлагагүй байдлаас үүдэж байна.

Нийт 34,429.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,991.3 сая төгрөгийг залруулж, бүртгэл тайлантай холбоотойгоор 1,603.1 сая төгрөгийн зөрчил, хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотойгоор 27,834.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.




3.1.6 Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийн дийлэнх хувь эзэлж байгаа Сум хөгжүүлэх сангийн зөрчлийг сумдаар ангилж үзвэл:

Засгийн газраас Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоог хөгжүүлэх чиглэлээр сумдын сум хөгжүүлэх сангийн дансанд 4,326.9 сая төгрөгийн эх үүсвэрийг санхүүжүүлсэн байна. Гэтэл сумдын сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, графикт хугацаандаа зээл хүүгээ төлөөгүйд тогтоосон төлбөрийн акт

1,718.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, мөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон 200.0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаас 200.0 сая төгрөгийн зээлийг олгосон байхад төлөгдөөгүй байна.

Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийг журмын дагуу төлүүлэх үүргээ хэрэгжүүлэхгүй мөртөө бусад эх үүсвэрээс мөн адил нөхцөлтэй зээлийг олгож байгаа нь аймаг орон нутгийн хөгжилд оруулах хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулах санхүүгийн зөрчлийг жил бүр нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгосон зэрэг зөрчил илэрлээ.



Дээрх графикаас 2018 оны тухайд Эсөнбулаг сумын СХС 260.6 сая төгрөг буюу хамгийн өндөр акттай байна. Харин СХС-гийн хугацаа хэтэрсэн авлага багатай сум нь Тонхил, Цээл сумууд байна.

ДӨРӨВ: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН НИЙТЛЭГ АЛДАА ЗӨРЧИЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хураангуйлан харуулбал:

- Цалингийн зардал, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, НДШ, ХХОАТ-тай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:
 - ✓ Цалин амралтыг давхардуулан, илүү дутуу олгодог, урьдчилгааг их хэмжээгээр олгож тухайн жилд суутган тооцоог хийдэггүй шууд зардалд тайлагнасан 92.9 сая төгрөгийн зөрчлийг 55 байгууллага гаргажээ.
 - ✓ Үр дүнгийн урамшууллыг илүү, дутуу тооцдог, мөн урамшуулал, шагналт цалин, ур чадварын нэмэгдлийг давхардуулан хавтгайруулан олгодог 29.4 сая төгрөгийн зөрчлийг 31 байгууллага гаргажээ.
 - ✓ ХХОАТ, НДШ-ийг илүү, дутуу суутгасан, тооцоо нийлээгүй, суутгалыг тухай бүр нь төлөөгүй 190.5 сая төгрөгийн зөрчлийг 62 байгууллага гаргажээ. /хавсралт№1/
- Авлага, өглөг, үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:
 - ✓ Харилцагчид төлөх төлбөрийг илүү, дутуу төлж санхүүгийн тайланд авлага, өглөгийг тусгадаггүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй 598.1 сая төгрөгийн зөрчлийг 28 байгууллага гаргажээ.
 - ✓ Хөрөнгө, бараа материалыг авсан хэмжээгээр нь тухай бүр орлого авдаггүй, нягтлан бодох бүртгэлд шууд зарлагаар бичилт хийдэг, зөрүүтэй үнээр орлого авдаг, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө зарж борлуулдаг 23,591.5 сая төгрөгийн зөрчлийг 60 байгууллага гаргажээ.

- ✓ Хөрөнгө биетээр ирээгүй байхад орлого авдаг, шууд зардалд тайлагнадаг 20.4 сая төгрөгийг 3 байгууллага гаргажээ.
 - ✓ Бусад эх үүсвэр, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд болон хөрөнгийг данс бүртгэлд тусагдаагүй 68.9 сая төгрөгийн зөрчлийг 14 байгууллага гаргажээ.
 - ✓ Анхан шатны нотлох баримтгүйгээр төсвийн хөрөнгийг захиран зарцуулдаг 408.4 сая төгрөгийн зөрчлийг 23 байгууллага гаргажээ. /хавсралт№2/
3. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, зардал, орон нутгийн орлоготой холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:
- ✓ УИХ-ын 2017 оны 29-р тогтоолыг зөрчиж албан тушаалтны гар утасны зардал төсвөөс төлсөн. Мөн УИХ-ын 67 дугаар тогтоолыг зөрчиж сахилгын шийтгэлтэй албан тушаалтан урамшуулал олгосон 26.5 сая төгрөгийн зөрчлийг 38 байгууллага гаргажээ.
 - ✓ Төсвөөс акт төлсөн 0.966 сая төгрөгийн зөрчлийг 5 байгууллага гаргажээ.
 - ✓ Батлагдсан төсвийг бүлгийн дүнгээр, зардлын зүйлээр хэтрүүлэн зарцуулсан 27.1 сая төгрөгийн зөрчлийг 15 байгууллага гаргажээ.
 - ✓ Төсвийн гүйцэтгэл, хэлбэлзлийг зөрүүтэй тайлагнадаг, зардлын зүйл ангийг зөрчиж гүйлгээ хийсэн 299.0 сая төгрөгийн зөрчлийг 39 байгууллага гаргажээ.
 - ✓ Тухайн жилийн орлогын тооцоог бодоогүй, НББ-д зөрүүтэй тусгасан.
 - ✓ Орон нутгийн орлогыг тасалсан, санхүүжилтийг илүү олгосон, орлого төвлөрүүлээгүй, төрийн сангийн дансанд тушаагаагүй 89.0 сая төгрөгийн зөрчлийг 23 байгууллага гаргажээ.
 - ✓ Өөрийн орлогыг зөвшөөрөлгүйгээр зарцуулсан 20.8 сая төгрөгийн зөрчлийг 4 байгууллага гаргажээ.
 - ✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулаагүй үлдэгдлийг өөр дансанд төвлөрүүлсэн 177.1 сая төгрөгийн зөрчлийг 20 байгууллага гаргажээ.
 - ✓ Орон нутгийн орлого нэмэгдүүлэх шийдвэр гараагүй, төсвийн хэмнэлт үүсээгүй байхад ОНХС-д санхүүжилт олгосон 167.1 сая төгрөгийн зөрчлийг 3 байгууллага гаргажээ. / хавсралт№3/
4. Төсвийн зарцуулалтын талаар:
- ✓ Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөвт хохирол учруулсан, илүү төлсөн 172.1 сая төгрөгийн зөрчлийг 4 байгууллага гаргажээ.
 - ✓ Жолоочийн шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, замын хуудасгүйгээр зарцуулдаг 137.7 сая төгрөгийн зөрчлийг 34 байгууллага гаргажээ.
 - ✓ Сайн малчны хандиваар өгсөн хөрөнгийг орлогоор бүртгээгүй 10.5 сая төгрөгийн зөрчлийг 10 байгууллага гаргажээ.
 - ✓ Албан томилолтын зардлыг илүү, дутуу олгодог 1.5 сая төгрөгийн зөрчлийг 8 байгууллага гаргажээ.
 - ✓ Хүнсний материалыг тендер шалгаруулаагүй компани, багцын нэр төрөл, үнэ зөрчиж, байгууллагын удирдлагын нэгдмэл сонирхолтой этгээдээс худалдан авалт хийдэг 146.2 сая төгрөгийн зөрчлийг 16 байгууллага гаргажээ. /хавсралт№4/
5. СХС, ТЭДС, Эмийн эргэлтийн сангийн хувьд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:
- ✓ СХС-гийн зээлийн гэрээний дагуу зээлийн төлбөрийг төлүүлдэггүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж эрх үүргээ биелүүлдэггүй. Шүүхийн шийдвэрээр төлөхөөр тогтоогдсон боловч аймгийн ШШГХ-тэй гэрээ байгуулж төлөх арга хэмжээ авдаггүй, зээлийн хугацаа дууссан иргэн аж ахуй нэгжийг шүүхэд хандаж шийдвэр гаргадаггүй. 946.7 сая төгрөгийн зөрчлийг 18 байгууллага гаргажээ.
 - ✓ Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээгээр нийлүүлсэн тракторын үнийн буцаан төлөлтийг тооцоход гэрээт хугацаанд

төлүүлээгүй, гэрээний дагуу алдангийг тооцоогүй 77.7 сая төгрөгийн зөрчлийг гаргажээ.

- ✓ Эмийн эргэлтийн сангийн хувьд статус тодорхой бус, улсын бүртгэлгүй, регистрийн дугааргүй үйл ажиллагаа явуулж байна. Мөн эмийг данс бүртгэлд тусгахдаа нэмэгдүүлсэн үнээр бүртгэдэг, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлдэггүй, үндсэн хөрөнгө нь орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлгүй 218.2 сая төгрөгийн зөрчлийг 19 байгууллага гаргажээ. байна. /хавсралт№5/
6. Хөндлөнгийн болон дотоодын хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлдэггүй гарсан зөрчил дутагдлыг дахин давтан гаргадаг.

ТАВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх үүргийн хэмжээнд Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалтад хамрагдах байгууллагуудын санхүүгийн аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн:

- Нэгж байгууллагын удирдлагуудад зөрчил арилгуулах зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн.
- Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлсэн.
- Санхүүгийн тайлангийн аудит хийхдээ өмнөх онуудын аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан үзэж хэрэгжүүлээгүй байгууллагын удирдлагыг эрх бүхий албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар албан тоот хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн нэгдсэн танилцуулгын дүнгээр Аймгийн удирдлагуудад дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуульд заасан эрх үүргээ ухамсарлан шат шатандаа зарчимч шаардлага тавьж ажиллах
2. Төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэг, ёс суртахуун, санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх
3. Эрх бүхий байгууллагаас хөрөнгө зарцуулахаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих албан тушаалтныг тодорхой зааж өгч гүйцэтгэл, үр дүнг тооцож хэвших
4. СХС-гийн зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлж түүнд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх ажил зохион байгуулах
5. ОНӨААТҮГ-удын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааны түвшин, үр дүнг дээшлүүлэх ажил зохион байгуулах
6. Барилга зураг зүйн товчоо, Орон сууцны алба ОНӨААТҮГ-ын татан буулгах комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж татан буугдаж байгаа аж ахуйн нэгжүүдийн, өр авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж дуусгалын тооцоо тайланг албан ёсоор гаргах ажлыг зохион байгуулах
7. Эмийн эргэлтийн сангийн статусыг тодорхой болгож, үйл ажиллагааг хуульд нийцүүлэх талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэн, санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу гаргуулах
8. Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх нь ард иргэдийн татварын мөнгийг зориулалтын дагуу зарцуулж үнэн зөв тайлагнах үндэслэл болно гэдгийг ухамсарлан аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн төсвийг хохиролгүй болгож, алдаа зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР